

С.Түмэндэлгэр

МУБИС-ийн Улс төр, социологийн тэнхимийн багш
Социологийн ухааны доктор /Ph.D/

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ХҮЧИРХИЙЛЭЛТ ЗАН ҮЙЛ, ТҮҮНИЙГ ӨӨРЧЛӨХӨД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Abstract: *The research results, studied questions related to violence against children, showed that many children were being subjected to any form of violence or abuse in Mongolia. Addressing the problem in secondary schools is paramount. The author aimed to suggest the effective ways to help schools for changing violent behaviors in adolescents. The article showed that effective strategies focus on: development of adolescents' positive leadership; use art and literatures; prevention from discrimination; prevention from drug and alcohol use and etc.*

Key words: *violence, abuse, behavioral change, adolescent, positive solutions of aggression and stress, prevention discrimination, prevention from drug and alcohol use.*

Хүүхэд тухайн нийгэмд зонхилгогч соёлд суралцан, бие даан амьдрах чадвартай болон төлөвших явдлыг нийгэмшилт хэмээн социологи авч үздэг. Ихэнх хүний нийгэмшилт төстэй явагдах ч, нэг талаас түүний эцэг эх, асран хамгаалагчид, үе тэнгийнхэн, сургууль гэх мэт ойр дотны орчноос гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нэвтрүүлэг, эргэн тойрон дахь танихгүй хүмүүсийн орчин гээд л тухайн нийгмийн макро орчин бүгд нөлөөлж байдаг, нөгөө талаас хүүхэд идэвхгүй дуурайгч хүлээн авагч төдийхөн биш, өөрийн нийгмийн шинжүүдийг өөртөө бүтээж байдаг. Гэхдээ бүх хүүхдүүдийн нийгэмшилт шулуун дардан замаар явагддаггүй ба зарим хүүхдүүдийн бага насандаа мэдэрсэн амьдралын гашуун туршлага нь заавал эзэмших ёстой зөв дадал, зан үйлийг эзэмшихэд саад болдог сэтгэл зүйн эмгэгт хүргэдэг байж болзошгүй байдаг¹. Амьдралын гашуун туршлага гэдэг нь юуны түрүүнд хүний нийгмийн орчинд өссөн эсэхийг багтаахаас гадна хэр зэрэг хүчирхийлэл, дарамтын орчинд өссөн бэ гэдгийг басхүү багтааж байдаг.

2006 онд БСШУЯ-ы захиалгаар, НҮБХС-ийн дэмжлэгтэйгээр “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл” сэдэвт судалгааг МУБИС-ийн багш нарын баг хийж гүйцэтгэсэн билээ. Уг судалгааны үр дүн сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл дарамт нэлээд нийтлэг шинжтэй үзэгдэл болсныг харуулсан ба тэр дундаа үе тэнгийнхний зүгээс бусдыгаа дээрэлхэх, доромжлох явдал хамгийн түгээмэл үйлдэгдэж байгааг илрүүлсэн². Үе тэнгийн сурагчдын хоорондын хүчирхийлэл дарамт нь нэг талаас нэг хэсэг хүүхэд хохирогч болох, нөгөө талаас нөгөө хэсэг хүүхдүүд гэмт хэрэгтэн болох урхаг ихтэй тул анхаарлын гадна орхиж болохгүй юм. Хэдийгээр насанд хүрээгүйчүүдийн үйлдэж буй гэмт хэргийн тоо жилээс жилд буурч байгаа ч, зохион байгуулалттай, бүлэглэн үйлдэх явдал өсөж, мөн хүүхэд гэмт хэргийн хохирогч болох явдал төдийлөн буурахгүй байна³. Уг асуудлыг ихэвчлэн эцэг эхийн хараа хяналт сул байгаатай холбон тайлбарладаг ба боловсролын байгууллагын зүгээс ямар арга хэмжээ авбал зохилтой болохыг орхигдуулах тал ажиглагддаг. Иймд уг өгүүллийн хүрээнд боловсролын байгууллагын хүрээнд хүүхдийн хүчирхийлэлт зан үйлийг арилгахад ямар асуудлуудад анхааран ажиллах нь оновчтой болохыг хөндөн өгүүлэхийг зорьлоо.

Хүчирхийлэл үйлддэггүй “мундаг” охид, залуус болон төлөвших хандлагыг бий болгох

Судалгаагаар үе тэнгийнхний хооронд гарч буй хүчирхийлэл дарамтад хөвгүүдийн (охидын хувьд харьцангуй бага) дундахь “хүчтэй нь мундаг” гэсэн уламжлалт соёл ихээхэн

¹ А.Гидденс (2006). Социологи. Улаанбаатар хот. Хуу-44

² БСШУЯ, НҮБХС, МУБИС, ХЭҮК (2006) Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Судалгааны тайлан. Улаанбаатар хот

³ Монголын криминологичдын холбооны мэдээлэл, судалгааны төв. 2011. Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн шалтгаан, нөхцөл. Судалгааны тайлан. (www.criminology.mn-ээс)

үүрэгтэй болох нь ажиглагдсан¹. Учир нь “мундаг” байх гэдэг дор бусдыгаа дээрэлхдэг, зоддог “атаман” гэж ойлгох явдал нь үе тэнгийнхний хоорондын хүчирхийлэлд ихээхэн нөлөөтэй бөгөөд энэ нь хүчирхийлэлт зан үйл бүхий хэн нэгнийг буруутгах нийгмийн хэм хэмжээ сул үйлчлэхэд хүргэх юм (Хүснэгт 1). Иймд хүчирхийлэлт зан үйлийг бууруулахад охид, хөвгүүдийн “мундаг” байх явдлыг хүч хэрэглэх явдалтай холбон үздэггүй хандлагыг хөгжүүлэх нь чухал юм.

Хүснэгт 1. Хүчирхийлэлд эерэг болон сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлс	
Хүчирхийлэлд түлхэгч хүчин зүйлс	Хамгаалах хүчин зүйлс
Эдгээр нь хүүхдийн эрүүл, аюулгүй, халдашгүй төлөв байдлыг эвдэхэд хүргэх хүчин зүйлс юм.	Эдгээр нь эрүүл мэнд, аюулгүй, аар сайхан төлөв байдлыг эвдэхээс хамгаалдаг хүчин зүйлс.
<ul style="list-style-type: none"> - Хүчирхийллийг зөвтгөн хүлээн зөвшөөрөх соёл - Биеэ тоох явдал - Хүчирхийлэл бүхий, сөрөг нөлөөтэй гэр бүлд амьдардаг - Олон нийт хүчирхийллийг буруушаадаггүй байх - Уур бухимдлаа дарж чадахгүй байх - Стресс ордог, түүнийг зохицуулж чадахгүй байх - Нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоогүй - Спортоор хичээллэдэггүй. - Зөрчилдөөнийг хүчээр шийдэх эрмэлзэл бүхий байх - Бусдыг алагчлах хандлага - Хариуцлагатай шийдвэрийг бие даан гаргах чадваргүй - Бусдын муу нөлөөнд автах - Архи, мансууруулах бодис хэрэглэх - Зэвсэг авч явах - Гэмт хэргийн бүлэглэлд нэгдэх - Дүрэм журам, хуулийг зөрчих - Буруу үйлдлээ дахин дахин хийх г.м 	<ul style="list-style-type: none"> - Хүчирхийллийг буруушаадаг соёл. - Өөртөө эерэгээр итгэх явдал - Эрүүл, тайван гэр бүлд амьдардаг - Эерэг олон нийт - Уур бухимдлаа зохистойгоор дарж чаддаг - Стрессээс урьдчилан сэргийлдэг, зохистойгоор шийддэг - Нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог - Спортоор хичээллэдэг - Зөрчилдөөнийг эвээр шийддэг - Бусдыг алагчилдаггүй - Хариуцлагатай шийдвэр гаргадаг - Бусдын сөрөг нөлөөг эсэргүүцдэг - Архи, мансууруулах бодисоос татгалздаг - Хүйтэн болон халуун зэвсэгт хариуцлагатай ханддаг - Гэмт бүлэглэлд орохоос зайлсхийдэг - Дүрэм журам, үүрэг хариуцлага, хуулийг дээдлэн, сахин биелүүлдэг - Өөрийгөө хамгаалах стратегийг хэрэгжүүлдэг - Буруу үйлдлээ ухааран, дахин хийхээс татгалздаг.

Энэ бүхэнд тулгуурлан хүчирхийллийг бууруулж, улмаар арилгахад дараах арга замыг туршин хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй хэмээн үзэж байна.

Өсвөр үеийн хөвгүүд хийгээд залуусын нэлээдгүй нь хүчирхийлэл хэрэглэхгүйгээр “мундаг” болж, бусдаас онцгойрч чадна гэдэгт итгэх нь ховор. Ер нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чадвар гэдэг нь өөрийгөө болон бусдыг эрүүл, аюулгүй байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах чадвар юм². Эдгээр чадварууд нь сурагчийг хүчирхийлэлт зан үйл гаргах, өөрийгөө хүчирхийллийн шинжтэй үйлдлээс хамгаалдаг болоход нь тусална. Юуны түүрүүнд тухайн сурагчид хүчирхийлэлт зан үйл илэрч байгаа эсэхийг тодорхойлох нь чухал. Үүнд сурагч өөрөө өөрийгөө тодорхойлох тестүүдийг ашиглаж болох юм. Мөн ямар зан үйл нь хүчирхийлэлт шинжтэй вэ гэдгийг мэддэг болоход нь туслах нь зүйтэй. Түүнчлэн бусадтай харилцахдаа ямар зан үйл гаргавал хүчирхийллийн хохирогч болж болзошгүй вэ гэдгийг хүүхэд мэдэж байх нь чухал. Иймд хүчирхийлэлт зан үйлийг өөрчлөхдөө дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- Хүчирхийлэлт зан үйлийг шууд өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх. Ингэхдээ өөртөө итгэх итгэлийг төлөвшүүлэх замаар хүүхдэд илэрдэг бусдаас ялгарах хүслийг нь ашиглан эерэг хэлбэрээр бусдаас ялгарах, тэргүүлэх, манлайлахад сургах нь чухал юм.

¹БСШУЯ, НҮБХС, МУБИС, ХЭҮК (2006) Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Судалгааны тайлан. Улаанбаатар хот

² LMeeks, Philip Heit, R. Page (1995) Violence Prevention. Glencoe/McGraw-Hill. Pp-6

- Хүчирхийлэлд хүргэгч хүчин зүйлсэд нь нөлөөлөх. Жишээ нь: өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэхийн тулд
 - Эерэг зорилтууд дэвшүүлдэг болгох,
 - Тусгай авьяас чадвараа хөгжүүлэхэд нь нөлөөлөх. Дугуйлан, секцийн үйлчилгээг нэмэгдүүлж, өргөтгөх
 - Сайн хийдэг зүйлээ мэддэг болоход нь туслах
 - Сургуульдаа шилдэг нь байхын тулд шургуу хөдөлмөр ихээхэн чухал болохыг төлөвшүүлэх
 - Хичээлээс гадуурхи үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 - Итгэлийг хүлээсэн насанд хүрсэн нэг хүнтэй болоход нь туслах.
 - Өөрт нь эерэгээр нөлөөлөх найз нөхөдтэй болоход нь туслах
 - Хүмүүст сайн дураар туслах
 - Ариун цэврийг сахихад нь туслах

Мөн зарим сургуулиудад хүчирхийлэлт зан үйл гаргахгүй байх талаар “Сурагчдын үүрэг, амлалт”-ыг авахуулдаг уламжлал байдаг аж. Үүнийг ашиглавал илүү үр дүнтэй байж болох талтай.

Хүчирхийлэлийг арилгахад урлаг, уран зохиолыг ашиглах нь

Урлаг, уран зохиол нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд тун хүчтэй нөлөөтэй. Урлаг, уран зохиол нь бусдын түүх, туршлагаас ямар нөхцөлд ямар үйлдэл хийх тухай хариуцлагатай шийдвэрийг гаргах, энэ талаар эргэцүүлэн бодох, өөрийн хүмүүжлээ үнэлэн дүгнэх, дутагдалтай талаа засахад нь тусалдаг¹. Түүнээс гадна хүчирхийлэлт үйлдэл болон архи, тамхи, мансуурах бодисоос хол байх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нэгэн арга хэрэгсэл болдог давхар давхар ач холбогдолтой. Урлаг, уран зохиол нь бусдыг харах цонх болохоос гадна өөрийгөө харж дүгнэх хэрэгсэл болдог. Урлаг, уран зохиолыг уншсаны дараагаар хэлэлцүүлэг өрнүүлбэл сайн. Түүнчлэн хэрэв хүүхэд урлаг, уран зохиолын авьяастай бол үүнийг нь хөгжүүлэх гарц бас нээгдэх юм.

Уран зохиолыг ашиглахдаа анги, түвшний ялгааг харгалзан үзэх нь чухал. Мөн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд тустай уран зохиолыг дээжсийг уран зохиол, монгол хэл, нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөр, сурах бичигт тусгах нь ихээхэн ач холбогдолтой юм.

Сайн нөлөө бүхий уран зохиолыг ашиглахдаа:

- Асуудал хөндсөн кино үзэж, ном уншсаны дараагаар сайн ба муугийн талаархи хэлэлцүүлэг өрнүүлэх,
- Бодит амьдрал дахь асуудалтай холбон ярилцах,
- Ийм арга хэмжээг нэг л удаа биш тодорхой давтамжтайгаар зохион байгуулж байх,
- Жүжигчилсэн тоглолт зохион байгуулах, жүжгийн дугуйлан ажиллуулах, Хүүхдүүдэд үзүүлэх тоглолт хийх. Нэг ангийн хүүхдүүд бүгд л нэг дүр авч байхаар эсвэл ээлжлэн авч байхаар зохион байгуулбал илүү ач холбогдолтой.
- Яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол эсвэл сонингийн нийтлэл бичүүлэх, уралдаан зарлах, хүүхдийн бүтээлийн сурталчлах. Захидал ч байж болно. Гомдоосон хэн нэгэндээ уучлал хүсэн захидал бичүүлэх гэх мэт.
- Дүрслэх урлагаар илэрхийлэхийг дэмжих. Ялангуяа зургаар илэрхийлүүлэх. Зургийн хичээлийн нэг сэдэв байхаар сонгох. Мөн уралдаан зарлаж болно. Мөн баримал, фото зураг зэрэг бусад дүрслэх урлагийн төрлүүдийг ашиглах.

Уур бухимдал, стрессийг тайлах ур чадваруудыг төлөвшүүлэх нь

Хүний баярлах, гуних, хөөрөх, догдлох, айх, уурлах, буригдах, ганцаардах, гуних, гансрах зэрэг сэтгэл хөдлөл нь бусадтай харилцах харилцаанд тань маш ихээр нөлөөлдөг. Хэрвээ хүүхэд эдгээр сэтгэл хөдлөлөө эергээр илэрхийлж чаддаг болох бол бусад хүмүүстэй сайнаар харилцаж чадна гэсэн үг. Хүүхэд уураа дотроо хадгалаад байх аваас улмаар өөрийгөө хүчтэй байна хэмээн мэдэрч улмаар энэ нь зодоонд хүргэх тал бий. Тэгэхээр уур бухимдал бол хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлс бөгөөд үүнийг явал илэрхийлэхгүй байх вэ гэдэгт суралцах нь ихээхэн чухал юм.

¹¹ LMEEKS, Philip Heit, R. PAGE (1995) Violence Prevention. Glencoe/McGraw-Hill. Pp-24

Эхний арга бол уурлахаас урьдчилан сэргийлэх явдал¹. Бусдыг сайн сонсох, өөрөө өөртэйгээ ярилцах зэрэг сайн аргуудын нэг юм. Үүний дараа уур бухимдлаа зохицуулж сурах нь ихээхэн чухал. Уур бухимдлаа дарах аргуудыг мэдэж, түүнийгээ ашиглан дадлагажих хэрэгтэй.

Үүний тулд:

- Уур бухимдлаа захирч сурах. Би юу мэдэрч байна, яагаад би үүнийг мэдрэх болов, миний уур хүрэх нь үндэслэлтэй зүйл мөн үү, би уураа яаж зөвөөр гадагшлуулах вэ гэдгээ захирч мэдрэх хэрэгтэй.
- Уур бухимдлаа хянахад чиглэсэн өөртөө хэлдэг үгсийг ашиглах.
- Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцох,
- Хэнд ч халдалгүйгээр биеийн үйлдлээр уур бухимдлаа гадагшлуулах,
- Идэвхтэй сонсох,
- Хошин шогийг ашиглах,
- Бүтээлч үйлдлээр илэрхийлэх,
- Багш, эцэг эхтэйгээ ярилцах,
- Уур бухимдлынхаа тухай захидал бичих,
- Уур бухимдлаа дарах тухай төлөвлөх зэрэг болно.

Уур бухимдлаа барихаас гадна стрессээ зөв зохицуулж сурах нь чухал. Стресс бол өдөр тутамд өөрөөс тань шаардах зүйлд бие махбодийн зүгээс хариу үйлдэл үзүүлэх явдал. Өөрөө хэлбэл хийх ёстой зүйлийнхээ тухай бодсоор байх. Өдөр тутмын шаардлагуудаас хүн бүр зугтах аргагүй. Тэгэхээр хүн бүрт стресстдэг ба харин стресст хариу үйлдэл үзүүлж байгаагаараа хүмүүс ялгаатай. Тэгэхээр сурагчийг стрессээ хүчирхийллийн бус аргаар шийдэж сурахад нь туслах чухал. Үүнтэй холбоотойгоор стрессийн төрлүүдийг мэддэг байх нь чухал. Мөн стресст хүргэдэг зүйлсийг мэддэг байх. Стресс орохоос урьдчилан сэргийлэхийг анхаарах нь зүйтэй.

Стрессээ зөв зохицуулахад чадварт:

- Хариуцлагатай шийдвэр гаргах чадвар,
- Зөв амьсгалах техникийн сурах,
- Зөв хооллох,
- Хангалтай унтаж, амрах,
- Биеийн тамирын үйлдэл хийх,
- Цаг ашиглалтын төлөвлөлт хийх,
- Хийх зүйл, заавал санах зүйлээ бичиж, тэмдэглэх,
- Дотны найз нөхөдтэй байх,
- Эцэг эх болон бусад итгэлтэй насанд хүрэгсэдтэй ярилцах,
- Бусдад туслах,
- Сэтгэл хөдлөлөө зохистойгоор илэрхийлэх,
- Нохой, муур тэжээх,
- Өөрийн гадаад байдлаа өөрчлөх,
- Хошин шогийн мэдрэмжтэй байх.

Ялгаварлан гадуурхалтаас зайлсхийхэд сургах нь

Нийгмийн янз бүрийн бүлгүүд зэрэгцэн орших явдалтай холбоотойгоор ялгаварлан гадуурхалтын асуудал яригдах ба үүнтэй хүчирхийлэлт зан үйл бас холбогдоно. Хүмүүс хэдийгээр ялгаатай ч, харилцан бие биенээ хүндэтгэх ёстой. Ялгаварлан гадуурхалт гэдэг нь тодорхой хувь хүн, бүлэгт өөрийн тогтсон үзлийнхээ дагуу нэг хэсэгт нь боломж олгож, нөгөөгийнх нь боломжийг хасах замаар ялгаатайгаар хандах явдал. Хамгийн гол нь хүмүүст ялгаатайгаар хандах явдалд хүмүүс нийгэмшдэг. Өөрөөр хэлбэл хүмүүс тодорхой төрлийн хүмүүст хандах тогтсон хандлагатайгаар төрдөггүй, харин нийгмээсээ суралцдаг. Аливаа төрлийн “изм”-үүд нь ялгаварлан гадуурхалтын үндэс болдог гэдгийг анхаарах хэрэгтэй.

Ялгаварлан гадуурхалтаас зайлсхийхийн тулд:

¹¹ LMeeks, Philip Heit, R.Page (1995) Violence Prevention. Glencoe/McGraw-Hill. Pp-28

- Хэвшмэл ойлголтуудаас татгалзах,
- Ялгааг хүлээн зөвшөөрөх,
- Бүх хүмүүст тааламжтай хандах,
- Ялгаварласан зүйл хэлэхээс татгалзах,
- Ялгаварлан гадуурхаж буй хэн нэгнээс ийм зан үйл гаргахгүй байхыг хүсэхэд суралцуулах нь чухал.

Архи, тамхи, мансуурах бодисоос татгалзахад сургах нь

Архи, тамхи, мансуурах бодисоос татгалзах тухай ярилгүйгээр хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын үнэ цэнэ ямагт буурах юм. Хаана согтууруулах, мансуурах зүйл хэрэглэж байна, тэнд хүчирхийлэл гардаг. 2011 онд 907 хүүхэд гэмт хэрэг үйлдсэнээс 4 хувь нь архидан согтуурсан байх үедээ үйлджээ. Ер нь үйлдэгдэж буй хүний бие махбодь, амь насны эсрэг гэмт хэргийн тохиолдлын 20.6 хувь нь үйлдэгч этгээд архидан согтуурсан байх үед гарсан байдаг аж¹.

Хүүхэд архи, тамхи, мансууруулах бодис гэж юу болох, түүний хор уршгийн талаар мэдлэгтэй байх нь тэдгээрийг хэрэглэхээс татгалзаж сурахад ихээхэн чухал. Зүгээр л хориглоод байхын оронд үр дагаврыг сайтар нь ойлгуулах хэрэгтэй. Архи, тамхи, мансуурах бодисгүй арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хүүхдүүд тэдгээрийг сонгон оролцох боломжийг бүрдүүлэх нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой. Ийм төрлийн үйл ажиллагаануудад:

- Хичээлээс гадуурхи арга хэмжээнүүд
- Бүжиг
- Репийн уралдаан
- Жүжиг тоглох,
- Карнивал
- Авъяасын үзүүлбэрүүд
- Хоолны тэмцээн
- Хувцасны үзүүлбэр зэрэг болно.

Архи, тамхи, мансуурах бодисоос татгалзахад үе тэнгийнхний хүчийг ашиглах, архи, тамхи, мансуурах бодисгүй бүсийг тогтоох, архи, тамхи, мансуурах бодистой холбоотой дүрэм журам бүхий байх, амлалтын аян өрнүүлэх зэрэгт тулгуурлах хэрэгтэй. Мөн зэвсэгтэй холбоотой бодлого ч байх нь чухал. Архи, тамхи, мансууруулах бодис нь хүчирхийлэлд өртөх, хүчирхийлэл үйлдэхэд ихээр нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлс. Хүн хариуцлагатай үйлдэл хийхийн тулд өөрийн зан үйлээ хянах ёстой. Гэтэл архи, тамхи, мансууруулах бодис нь өөрийгөө хянах чадварыг алдагдуулж улмаар дараах эрсдэлт үйлдлүүдийг хийхэд хүргэдэг. Үүнд:

- Зодолдох, хэрэлдэх, халдлага. Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэснээр ухамсартай үйлдэл хийж чадахгүйд хүрдэг ба уур, стрессээ захирч чаддаггүй. Тэд зөрчилдөөнийг эв зүйгээр зохицуулахаас илүү шууд л хэрүүл тэмцэл, зодоонд хүрдэг.
- Сургуулиа хаяхад хүргэдэг. Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэж сурсан нэлээд тооны хүүхдүүд сургуулиа төгсөж чадалгүйгээр хаяхад хүрдэг. Энэ нь хэд хэд учир шалтгаантай. Нэгд, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн үед сурах зүйлдээ анхаарлаа төвлөрүүлж чаддаггүйгээс үеийнхнээсээ хоцорч эхэлнэ. Ихэнх сургуулийн дүрмүүдэд архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн хүнийг сургууль руу оруулахгүй байх, улмаар удаа дараа хэрэглэж байгаа тохиолдолд сургуулиас хөөх арга хэмжээ авдаг.
- Бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх эсвэл тийм үйлдэл хийхэд хүргэдэг. Нөгөө хүн нь татгалзаж байгаа эсэх, нөгөө хүнийхээ хүсэл сонирхлыг харгалзан үзэж өөрийн үйлдлээ хянах чадвараа алддаг тул архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэн өсвөр үеийнхэн хүчингийн гэмт хэрэг өдүүлэх явдал олонтаа гардаг. Түүнчлэн архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн охид бусдад хүч хэрэглүүлэх, тэрнээс өөрийгөө хамгаалах чадвараа алддаг.
- Хулгай дээрэм хийх. Архи, тамхи, мансууруулах бодисны хэрэглээ нь ихээхэн мөнгө шаарддаг. Иймд тэр зүйлээ хэрэглэхийн тулд байгаа мөнгөө орж дуусахын зэрэгцээ өөрийн дотны хүмүүс, гэр орон, цаашлаад үл таних хүүүүсийн эд зүйлсийг хулгайлдаг. Ахиад л гэмт хэрэгтэн болж байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх. Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн хэн нэгэн гэр бүлийн гишүүдийн санаа зовинол, уур бухимдлыг хүргшэж, стрессийг нээгдүүлдэг. Тэдний зүгээс тавьсан

¹ Монголын криминологичдын холбооны мэдээлэл, судалгааны төв. 2011. Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн шалтгаан, нөхцөл. Судалгааны тайлан. (www.criminology.mn-ээс)

зүй ёсны шаардлагыг архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн этгээд хүлээн авах чадваргүй байдаг. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн бусад гишүүдээ зодож танхайрах, сэтгэл санааны дарамтад оруулах нь олонтаа. Маш олон хүүхэд архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн хэн нэгний хүчирхийллийн золиос болсон байдаг.

- Амиа хорлох. Архи, тамхи, мансууруулах бодисны байнгын хэрэглээ нь сэтгэл гутраод хүргэдэг. Өөрийгөө ялж чадахгүй байна гэсэн өөртөө итгэх итгэлийн уналт нь улмаар амиа хорлоход хүргэдэг тал бий.
- Аллага үйлдэх зэрэг сөрөг үр дагаварт хүргэх тал бий. Судалгаагаар нийт санаатай/санамсаргүй аллагын гэмт хэргийн нэлээдгүй нь архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн үед гарч байна. Зам тээврийн осол ч бас архи, тамхи, мансууруулах бодисны хэрэглээтэй холбогдож байна.

Дүгнэлт

Сургуулийн зүгээс охид, хөвгүүдийн хүчирхийлэлт зан үйл төлөвших, хүчирхийлэл\дарамтад өртөхөөс сэргийлэхийн тулд тодорхой бодлого, төлөвлөгөөтэйгээр ажиллах нь ихээхэн ач холбогдолтой юм. Сургуулийн зүгээс хүчирхийллийг бууруулж, улмаар арилгахдаанэгд, охид хөвгүүдийн өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх замаар эерэг манайллыг хөгжүүлэх, хоёрт, урлаг, уран зохиолыг ашиглах замаар хүмүүжил, төлөвшилд нь эерэгээр нөлөөлөх зэрэг аргуудыг ашиглах нь олон улсын практикаас ажиглагдаж байна. Түүнчлэн хүчирхийлэл\дарамтад нөлөөлөгч хүчин зүйлсийг саармагжуулах, бууруулах, оновчтойгоор зохицуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал аж. Ялангуяа уур бухимдал, стрессийг тайлах ур чадваруудыг эзэмшүүлэх, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас зайлсхийхэд сургах, архи, тамхи, мансуурах бодис хэрэглэхээс ухамсартайгаар татгалздаг болгон төлөвшүүлэхэд анхаарах хэрэгтэй бөгөөд эдгээр нь ганц нэг удаагийн арга хэмжээ хэрэгжүүлснээр амжилттай хэрэгжүүлэх боломжгүй юм. Иймд хичээлийн болон хичээлээс гадуурх арга хэмжээнүүд нь охид, хөвгүүдийн нийгэмшил, төлөвшил, хөгжилд нь чухал хувь нэмэр оруулах дээр дурьдсан үйл ажиллагаа, үзэл санааг тусгахад анхаарах цаг болжээ.

Ном зүй

1. А.Гидденс (2006).Социологи. Улаанбаатар хот. х,44
2. БСШУЯ, НҮБХС, МУБИС, ХЭҮК (2006) Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Судалгааны тайлан. Улаанбаатархот
3. Монголын криминологичдын холбооны мэдээлэл, судалгааны төв. 2011. Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн шалтгаан, нөхцөл. Судалгааны тайлан. (www.criminology.mn-ээс)
4. LMeecks, Philip Heit, R.Page (1995) Violence Prevention. Glencoe/McGraw-Hill. Pp-6